**ТӨВ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/385 Зуунмод

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд үржүүлэгдэж буй нутгийн Баянцагаан хонинд хянан магадлагаа явуулах ажлын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, хийгдсэн ажлын талаар тайланг танилцуулж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т даалгасугай.

3. Хянан магадлагаа хийхэд шаардлагатай судалгаа, мэдээллийн сан холбогдох материалуудыг ажлын хэсэгт гарган өгч ажиллах нөхцөл, боломжоор хангахыг Баянцагаан сумын Засаг дарга (Д.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

4. Хянан магадлагааны ажилд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийн зардлыг аймгийн Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлж, Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), хуваарилагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулахыг Баянцагаан сумын Засаг дарга (Д.Хүрэлбаатар)-д тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 29 -ны өдрийн
А/385 дугаар захирамжийн хавсралт

НУТГИЙН МОНГОЛ БАЯНЦАГААН ХОНИНЫ ҮРЖИЛ, АШИГ ШИМИЙН ЧАНАРЫГ СУДАЛЖ ТОГТООСОН АЖЛЫН ҮР ДҮНГ ТООЦОХ, ХЯНАН МАГАДЛАГАА ЯВУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын төрөл | Зардал | | |
|---|---|---|---|---|
| | | Нэг бүрийн үнэ /төг/ | Хэмжих нэгж | Бүгд үнэ /төг/ |
| 1 | Завсарлагааны цайны зардал | 2000 | 30хүн | 60000 |
| 2 | Үдийн хоолны зардал | 10000 | 30хүн | 300000 |
| 3 | Оройн хоолны зардал | 10000 | 30хүн | 300000 |
| 4 | Унааны зардал | 2490 | 350км х 2 машин | 350000 |
| 5 | Эрдмийн зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс | 50000 | 10хүн | 500000 |
| 6 | -Унааны зардал | 2490 | 350км х 2 машин | 350000 |
| 7 | -Унааны зардал | 2490 | 1000км х 2 машин | 400000 |
| 8 | Баянцаган сумын улс, аймгийн аварга малчин, мал бүхий иргэдтэй уулзаж түүвэр судалгаа хийх, санал бодол солилцох зардал<br>Шатахууны зардал | 2490 | 20 х 4 = 80малчин өрхөөр орно.<br>1500 км | 240000 |
| 9 | Бүтээл хэвлүүлэхтэй холбогдсон бичиг хэргийн зардал | | | 500000 |
| | | | | |
| НИЙТ ДҮН: | | | | |
| Үйл ажиллагаанд | | | | 3.000.000 |
| Шатахуун | | | | 1.660.000 |
| | | | | 1.340.000 |

ЗАРДАЛ ТООЦСОН:
ХХААГАЗРЫН МҮА-НЫ МЭРГЭЖИЛТЭН С.ТУЛГА
ХЯНАСАН:
СТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ч.ЦЭЦЭГСҮРЭН